



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 05-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-22

1. Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал	5-8
2. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах /	8-22

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 77 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, С.Ганбаатар, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Б.Түвшин, А.Ундраа, О.Цогтгэрэл, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Батбаатар, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, С.Лүндэг, Г.Очирбат;

Тасалсан: Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, Л.Энх-Амгалан, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-11 минут, Ц.Баатархүү-04 минут, Д.Батлут-03 минут, Э.Бат-Амгалан-02 минут, Б.Батцэцэг-17 минут, Ж.Бат-Эрдэнэ-04 минут, Д.Ганбат-02 минут, М.Ганхүлэг-16 минут, Б.Жавхлан-03 минут, Г.Лувсанжамц-02 минут, Т.Мөнхсайхан-03 минут, З.Мэндсайхан-12 минут, Ч.Номин-03 минут, Э.Одбаяр-17 минут, С.Одонтуяа-03 минут, Б.Пунсалмаа-02 минут, О.Саранчулуун-07 минут, Л.Соронзонболд-07 минут, Ц.Туваан-13 минут, Г.Хосбаяр-12 минут, Б.Хэрлэн-31 минут, Ж.Энхбаяр-02 минут, М.Энхцэцэг-03 минут.

Нэг.Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай саналаа танилцуулав.

Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./14:14/

Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг завсарлага авсантай холбогдуулан Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал хойшлогдов.

Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Гэр бүлийн бодлогын газрын Хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Э.Болормаа, С.Зулпхар, Б.Бейсен, А.Ариунзаяа, М.Мандхай, Д.Бум-Очир, Д.Ганбат, Ц.Туваан нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Гэр бүлийн бодлогын газрын Хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78

Татгалзсан: 23

Бүгд: 101

77.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Д.Батбаяр, Э.Одбаяр, Ж.Баясгалан нарыг дэмжсэнээр тооцож, 81.2 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 03 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж, 126 гишүүнээс 77 гишүүн ирж 61.1 хувиар ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал.

Гуравдугаарт, Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Казакстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Засгийн газар 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн соёрхон батлах тухай асуудал.

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурлын дэд дарга томилогдсонтой холбоотойгоор Улсын Их Хурлын даргын үүргийг гүйцэтгүүлэх Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан бүлгээс албан бичиг ирээгүй байна. Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай 1 дүгээр асуудлыг хэлэлцэж эхэлье.

МАН-ын бүлгийн Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 8 дугаар дүгнэлт, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хуралдааны шийдвэр, Улсын Их Хурлын ХЗБХ, ТББХ-ны 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны танилцуулга зэргийг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяаг дэд даргын албан тушаалаас нь огцруулах саналыг оруулж байна аа.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн саналыг дэмжин шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танд баярлалаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Хишигдэмбэрэлийн Тэмүүжин бүлгийн дэд дарга үг хэлнэ ээ.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын гишүүдийн өнөөдрийн өдрийн мэндийг хүргэе. АН-ын бүлэг өчигдөр хуралдаад шийдвэр гаргасан. Ямар шийдвэр гаргасан бэ гэхээр бид бол Үндсэн хуулийг дээдлэх, ардчиллыг дэмжих, парламентын засаглалыг дэлгэрүүлэх тал дээр бол байнгын энэ зүг рүү хатуу шаардлага тавьж ажиллана гэдэг ийм зарчимтай нам.

Тийм учраас ҮХЦ-ийн гаргасан дүгнэлтэд дурдагдсан зүйлүүдийг бол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх ёстой гэж АН-ын бүлэг үзсэн.

Хүлээн зөвшөөрөхтэй холбогдуулаад бол ямар асуудлууд хөндөгдөж байгаа вэ гэхээр Улсын Их Хурлаас баталсан 95 дугаар тогтоол цаашид яах юм бэ гэдэг асуудлыг яригдах ёстой. ҮХЦ-ийн дүгнэлт Улсын Их Хуралд ирсэн. Үндсэн хууль дээр маш тодорхой байгаа.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйл дээр үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргаантай асуудлыг ҮХЦ хэлэлцээд дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна. Оруулсан асуудлаар Улсын Их Хурлын шийдвэртэй холбоотой байх юм бол Улсын Их Хурал хүлээж аваагүй бол ҮХЦ эцэслэн шийдвэрлэнэ. Дахин хянан үзэж гэдэг ийм зохицуулалттай. Тэгээд өнөөдрийн яг энэ чуулганы хуралдаан болон өмнөх Байнгын хороодын хуралдаан дээр Улсын Их Хурлын 95 дугаар тогтоолыг яаж шийдэх тухай ярилцаагүй. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн дагуу Улсын Их Хурал ямар шийдвэр гаргах тухай ярилцаагүй.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйл дээр маш тодорхой зааснаар бол яг энэ Улсын Их Хурлын шийдвэртэй холбоотой асуудал дээр бол Улсын Их Хурлын олонх хүрэлцэн ирж саналаа ил гаргах замаар шийдвэрлэх ёстой. Тэгж байж хүлээж авсан аваагүй гэдэг асуудал хөндөгдөнө. Тэгээд манай намын өчигдрийн мэдэгдэл дотор маш тодорхой заасан байгаа. 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн их суудлын хуралдаанаар 8 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх нь хууль ёсыг дээдлэх энэ зарчимд нийцнэ гэж үзсэн учраас Улсын Их Хурал энэ хүлээн зөвшөөрөх ажлаа хийх ёстой. Энэ ажлаа хийгээгүй үл ойлгогдох байдалтай байгаа учраас хэлэлцэж байгаа өнөөдрийн энэ асуудал дээрээс АН 5 өдрийн завсарлага авч байна аа. Бүлгээрээ дахин бид нар ярилцах шаардлага байгаа.

Б.Пүрэвдорж: МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

Ж.Батжаргал: Их хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулаад эрх зүйн хувьд олон олон асуудлууд яригдаад байгаа. Тэр асуудлууд нээлттэй. Үндсэн хуулийн 24 дүгээр зүйл Их Хурлын тухай

хуулийн 14 дүгээр зүйлд Улсын Их Хуралд бүлэгтэй улс төрийн хүчин Улсын Их Хурлын дэд даргатай байхаар заагдсан юм аа.

Тийм учраас манайх энэ бүрэн эрхийнхээ хүрээнд өөрөө дотооддоо асуудлаа ярьж тодорхой асуудлуудаа шийдээд Их Хуралдаа саналаа оруулж ирж байна аа. Их Хурлыг бүрдүүлж байгаа 2 том улс төрийн хүчин харилцан бие биеийнхээ үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаад МАН-ын бүлгийн их хуралдаа оруулж ирж байгаа асуудлуудыг дэмжин шийдэж өгөх ёстой гэсэн би ийм саналтай байна. Тэр 95 дугаар тогтоолын асуудал бусад асуудлууд ярих нь нээлттэй. Тэр бол Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхийн хэмжээний асуудал аа.

Тийм учраас энэ ярьж байгаа асуудлуудыг хэдүүлээ эрх зүйнх нь хувьд зааглаж ярих ёстой. Нэгэнт ҮХЦ тодорхой асуудлыг авч үзээд зөрчил үүсгэсэн байна гээд гаргачхаж байгаа учраас Их Хурлын гишүүн, бүлгийн гишүүн итгэл хүлээлгэж улс төрийн дэмжлэг үзүүлсэн хүнээ хариуцлага тооцож огцруулах тухай асуудлыг нь шийдээд бүлэг дэд даргатай байх, Их Хурлын дэд даргатай байх энэ эрхийнхээ хүрээнд дараагийнхаа дэд даргыг нэр дэвшүүлж байгаа асуудал нь бол ҮХЦ-ийн дүгнэлтийг авч хэлэлцэхгүй байгаатай холбоотой асуудал биш ээ.

Бид бүлэгт хамаарагдаж байгаа эрхийнхээ хүрээнд асуудлаа түрүүчээс нь шийдлээ. Тийм учраас тэр Цэцийн дүгнэлтээр Их Хурлын 95 дугаар тогтоолыг яах вэ гэдэг асуудлыг Их Хурал хэлэлцэх эрх нь нээлттэй байгаа. Тийм учраас энэ хуралдаанаа үргэлжлүүлээд МАН-ын бүлгээс оруулж байгаа саналыг дэмжин шийдвэрлэж өгөөч гэдэг хүсэлтийг тавьж байна аа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Ганбат гишүүн Даваасүрэн гишүүн нарын хувьд хэлэхэд Дэгийн тухай хуулиар урьд өдрийн 17 цагаас өмнө бүлгийн даргаар дамжуулан горимын санал гаргах, үг хэлэх бол албан бичиг ирүүлэх ёстой. Харамсалтай нь тийм албан бичиг ирээгүй байна. Тийм учраас та 2 үг хэлэх боломжгүй. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйл хуралдаанаас завсарлага авах, 12.1 энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам эвслийн бүлэг нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй.

Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно оо гэж заасан байгаа. Энэ 12.1-ийн дагуу АН-ын бүлэгт ажлын 5 өдрийн завсарлага өглөө. Ингээд Их Хурлын даргыг огцруулах тухай асуудлаас АН-ын бүлэг завсарлага авсан учраас огцруулах тухай асуудал хэлэлцэгдэхгүй. Тийм учраас дараагийн 2 дахь асуудал буюу Их Хурлын дэд даргыг томилох тухай асуудал байж болохгүй. Яагаад гэвэл нам эвслийн бүлгээс 1, 1 дэд даргатай байх тухай асуудал байгаа. Гэтэл огцруулах тухай асуудал явагдаагүй учраас Булгантуяа дарга дэд дарга хэвээрээ байгаа.

Тийм учраас Бат-Эрдэнэ даргыг томилох тухай асуудал 2 дугаар асуудал хэлэлцэх асуудлаас хасагдаж байна аа.

Хэлэлцэх асуудал гурав.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Казакстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Энэ асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир танилцуулна аа. Индэрт урьж байна.

Т.Аубакир: Монгол. Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, 2 улсын иргэдийн нийгмийн хамгаалал, нийгмийн харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэний нэгэн адилаар тэтгэвэр тэтгэмж авах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж ирлээ. Одоогийн байдлаар ОХУ, БНСУ, Унгар улс, БНПУ БНТУ, БНЧУ-тай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулж шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, шимтгэл төлсөн хугацаанд ноогдох тэтгэвэр тогтоолгон авах. Нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцсон хэлэлцээрийг хэрэгжүүлж байна аа.

Түүнчлэн БНКАУ, БНАУ, Австралийн холбооны улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр шинээр байгуулах, ОХУ-тай байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж байна аа.

Энэ хүрээнд БНКАУ-тай 2018 оноос Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, 2 улсын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар талууд хэлэлцээрт 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуулиудад зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм аа.

Монгол Улс Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль батлагдаж хэрэгжсэнээр 2 улсын иргэд Монгол Улс болон БНКАУ-д ажилласан шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн тооцуулж өндөр насны тэтгэвэр тогтоолгох, мөн Монгол Улсын иргэд БНКАУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдэж нийгмийн хамгааллын баталгаа нь сайжрах юм аа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар бусад хуульд

нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдахгүй юм аа.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Тилеуханы Аубакир сайдад баярлалаа.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хажикбэрийн Жангаабыл танилцуулна аа. Индэрт урьж байна.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын Дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казакстан Улсын Засгийн газар Хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр 2 улсын иргэд Монгол Улс болон БНКАУ-д ажилласан, шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн тооцуулж өндөр насны тэтгэвэр тогтоолгох мөн Монгол Улсын иргэд БНКАУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдэж нийгмийн хамгааллын баталгаа нь сайжрах талаар дурдсан байна аа.

Хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, Монгол Улсын иргэд ажиллаж амьдарч байгаа бусад улсдаа энэ төрлийн хэлэлцээрийг байгуулснаар БНКАУ-д ажиллаж, амьдарч байгаа манай улсын иргэдэд ямар ямар давуу тал үүсэх, Монгол Улс ажиллах хүчний хомсдолд орж байгаа асуудлын талаар асуулт асууж хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд цаашид иргэдийн эрх ашгийг хамгаалсан Монгол Улсын гадаад бодлогод нийцсэн гэрээ хэлэлцээрийг байгуулж ажиллах талаар үг хэлсэн болно оо.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газрын хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жангабыл гишүүнд баярлалаа.

Тэгэхээр танхим дүүрэн сууж байгаа Их Хурлын гишүүддээ баярлалаа. Энэ хуулийг соёрхон батлах нь 3-ны 2-оор шийдэгдэх учраас бүгдээрээ сууж байгаад нийт гишүүдийн олонхоор шийдвэрлэх учраас танхимдаа түр сууж байхыг хүсье.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Лхагвасүрэнгийн Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын хэлтсийн дарга, Бямбаагийн Мөнхбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч.

Хууль санаачлагчдын илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Энэ ямар олон хүн үг хэлж байгаа юм. Уул нь бол энэ Их Хурлаар нэлээн хэлэлцээд олон хүмүүс үг хэлчихсэн юм шүү дээ. Түрүүн үгээ хэлээд нэлээн олон хүмүүс ярьчихсан. Энэ нэрсээ татах гишүүд байна уу? Нэрсээ татчихаач. Бейсэн ах татаж хэрэггүй та заавал үг хэлэх ёстой.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу? Манай улсын хувьд бас нүүдэлчин соёлтой ахан дүүсийн барилдлага тогтоосон Казак түмэн. Казак түмний хөгжлийн асуудал энэ Улсын Их Хурлаар орж ирж байгаа нь их чухал. 1990-ээд оны эхэн үед бас Монгол Улсаас Монгол Улс ардчилал чөлөөт нийгмийн тогтолцоо руу шилжихтэй зэрэгцээд олон мянган Казак иргэд Казахстан улс руу нүүдэллэж зарим нь буцаж ирж байсан. Тэгэхээр ер нь бол бусад улстай харьцуулахад манай улсад 2 улсын ийм кэйс байгаа. Нэг нь болохлоор Казахстан. Нөгөөдөх нь болохоор Монгол иргэд олноороо аж төрж амьдарч байгаа БНСУ буюу Өмнөд Солонгос улс байгаа. Тэр утгаараа яг энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэгдээд орж ирж байгаа энэ асуудлыг Улсын Их Хурал соёрхон батлах нь зүйтэй гэж дэмжиж байгаа юм аа.

Ажлын хэсгээс асуухад манай улсын иргэд бас Турк, АНУ бусад улсуудад ажиллаж амьдарч байгаа.

Тэгэхээр ер нь бол Казахстан улстай хийх энэ гэрээтэй Соёрхон батлагдах энэ гэрээтэй ижил төрлийн цаашлаад хэдэн улстай Монгол Улсын иргэдийн ажиллаж амьдарсан НДШ-ийг шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцуулах ийм судалгаа байгаа вэ гэдэг асуултыг асуумаар байна.

Пүрэвдорж дарга аа ажлын хэсгээс.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгээс хариулъя.

Дөрөвдүгээр индэр нэрээ хэлээд хариулаарай.

Б.Пүрэвдорж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Мөнхзул.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газар 2 талт хамтын хэлэлцээрээр БНАУ, ОХУ, Австралийн холбооны улсуудтай хэлэлцээр хийх түвшинд буюу эцсийн шатанд байна. Одоогийн байдлаар батлагдсан хэлэлцээр БНПУ, Чех улс мөн түүнчлэн БНСУ дээр харилцан шимтгэл чөлөөлөх ийм хэлэлцээртэй байна. БНУ улстай хэлэлцээр батлагдсан. Цаашдаа бид нарын зорьж байгаа асуудал маань юу вэ гэхээр АНУ-д амьдарч байгаа Монголчууд АНУ-д ажиллаж амьдарч байгаад буцаж эх орондоо ирэх тохиолдолд АНУ-ын Сочо секьюрити системд төлсөн тэр даатгалыг мөнгийг буцааж олгуулах талаар хэлэлцээрийн шимтгэлийг 2 тал зэрэг төлөхгүй байгаа гэсэн энэ хэлэлцээрийн хэлбэрийг батлуулахаар Монгол Улсаас АНУ-д ЭСЯ-аар дамжуулан нэлээд эрчимтэй холбооны тухайн улсын Засгийн газартай хэлэлцэж байгааг дашрамд дурдъя аа.

Мөн түүнчлэн Канад, Швед, Австрали, Австри улсуудад бол бид Канад Швед улсуудад хэлэлцээрийнхээ саналын хүсэлтийг тавьсан. Холбогдох талуудаас хэлэлцээрийг одоо бид нар судалж байна гэсэн хариу өгсөн байгаа. Асуудлын гол нь хаана ч шимтгэл төлсөн бай тэтгэвэрт гарах үедээ 2 талаасаа тэтгэврээ авах ийм үндсэн зохицуулалт бүхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газраас санал болгож ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Мөнхзул дарга байж байгаарай. Ер нь бол энэ хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн тоо бол гадаад яамнаас авагдсан өнгөрсөн жилийн тоогоор бол 230-аас 40 орчим мянга байна гэж үзэж байгаа. Хилийн чанадад байгаа Монголчуудын хувьд бол үнэхээр бор зүрхээрээ ажиллаж, амьдарч, сурч, боловсорч байгаа. Тэр тусмаа БНСУ болон АНУ-уудад бас албан ёсны эрхтэйгээр биш хашилт дотор хэлэхэд хууль бусаар гэж нэрлэгдээд байгаа энэ хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байгаа. Ер нь бол хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын иргэд жилдээ асар их хэмжээний мөнгөн гуйвуулгыг Монгол Улс руугаа шилжүүлж байгаа. Энэ нь бол шууд болон шууд бус утгаараа Монголын эдийн засагт валютын нөөцийг нэмэгдүүлэх эдийн засгийг тэлэх маш том боломж болж байгаа шүү.

Энэ утгаараа бол эх орноосоо хол хилийн чанадад, хүний нутаг гүний хошуунд ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдээ дэмжих.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: 2023 оны эцсийн байдлаар Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас гаргасан тоо баримтаар нийт 208 мянган Монгол Улсын иргэн гадаад улс улсад оршин сууж байгаагаас албан ёсны хөдөлмөр эрхэлж байгаа нь 119 мянга буюу 50 орчим хувьтай л гэсэн ийм мэдээлэл байгаад байгаа юм. Тэгэхээр ерөнхийдөө Монгол Улсын иргэн эрх зүйн ямар статусаар тухайн оронд амьдарч байгаагаас үл шалтгаалаад хэрвээ татвар, НДШ төлж байгаа бол түүндээ ноогдох нийгмийн хамгааллын баталгаагаа шаардах эрхийг хангуулах чиглэлээр л бид хэлэлцээрийгээ санал тавьж ингэж явж байгаа. Бусад улсуудын зүгээс бол албан

ёсоор амьдарч байгаа иргэнд илүү нийгмийн хамгааллыг үзүүлэх гэсэн ийм чиглэл баримталдаг. Гэсэн хэдий боловч бид нар үйлдвэрлэлийн ослын даатгал эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг энэ наад захын хүний эрхийн асуудлууд дээр санал тавьж ажилладаг.

Тэгэхээр Солонгос улсад бол хамгийн нааштай хэлэлцээрийн хувьд Солонгост ажиллаж байгаад буцаж хилээр гарсан тохиолдолд төлсөн шимтгэлээ бүгдийг нь авчхаж байгаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна.

Энхбатын Болормаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Э.Болормаа: Ингээд өнөөдрийн чуулганаар соёрхон батлагдах гэж буй Засгийн газар хоорондын хэлэлцээр маань ер нь стратегийн ач холбогдолтой ийм хэлэлцээр байгаа гэдгийг онцлон хэлмээр байна. Монгол Улсын иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг бол олон улсын түвшинд хүргэх ийм зорилттой. Сая Эрдэнэболд гишүүний хэлсэнчлэн Монгол Улсын олон иргэд бас бусад улсуудад хөдөлмөр эрхэлж ажиллаж амьдарч байгаа.

Тэгэхээр тэдгээр иргэд маань ихэнхдээ нийгмийн даатгал нь тасалдсан байдаг бол тухайн улсдаа нийгмийн даатгалаа төлж байгаа бол иргэн Монголдоо ирэхдээ тэтгэврээ тогтоолгох нийгмийн хамгааллын энэ бодлогыг баталгаажуулж байгаа ийм чухал зүйл байгаа. БНКАУ-даа бид энэ Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээрийг маш олон жил олон засгийн газрууд ажиллаж өнөөдөр ийм соёрхон батлах түвшинд хүрч ирсэнд талархалтай байна. Тэгээд онцгойлон энэ салбарын сайд нараар ажиллаж ирсэн өнөөдөр соёрхон батлахад нь оролцож байгаа Аубакир сайд, Булгантуяа сайд, Ариунзаяа сайд гээд яг энэ салбарын олон сайд нарын ажлын үр дүн юм гэдгийг онцлон хэлмээр байна аа. Энэ дээр нэг зүйлийг чухалчилж хэлэх нь энэ хэлэлцээрийн зорилго бол эргээд Монгол Улсдаа ирэхэд тэтгэврээ тогтоолгох, гадаад улсад олон жил ажиллаж хөдөлмөрлөж ирчхээд Монгол Улсдаа эргэн ирж, нийгмийн баталгаа нь хангагдаж тэтгэврээ тогтоолгох. Үүнтэй адилхан бид тэтгэврийн шинэчлэлээ яаруулах ёстой. Гадаад улсад хөдөлмөрлөж хөдөлмөрлөж ирдэг. Тэндээ шимтгэл төлөөд явж байтал Монголдоо ирсэн чинь тэтгэвр нь тогтоолгохдоо бараг бага орлоготой иргэдийн түвшинд аваачих ийм нөхцөл байдал үүсчихсэн байгаа.

Манай тэтгэврийн тогтолцоо бол шударга бус байгаа. Олон ахмадууд өнөөдөр яаж та хэд 600, 700 мянган төгрөгөөр бүтэн сар амьдраад байгаа юм бэ гэдэг маш чухал асуудлыг хөндөж байгаа. Засгийн газар багш нарын цалин дээр шийдэл гаргаж Улсын Их Хуралд оруулж ирэхээр болсон байгааг сонсоход таатай байна аа. Одоо харин бид тэтгэврийн шинэчлэлийг энэ зөвхөн тэтгэврийн үнийн дүнг нэмэх биш энэ цаашдаа яаж энэ тэтгэврийн тогтолцоо, нийгмийн хамгааллын тогтолцоо шударга байх вэ? Нийгмийн үндсэн суурь гэрээ шударга байх вэ гэдэг энэ асуудлыг мөн цаг алдалгүй хийх ёстой байгаа.

Тэгэхээр өнөөдөр энэ асуудал буюу Засгийн газар хоорондын хэлэлцээр соёрхон батлагдах гэж байгаад баяртай байна. Харин Монгол Улсын иргэд маань Казакстан улсад ажиллаад эргэж ирээд Монголдоо тэтгэвр тогтоолготно тэр нь шударга байх, нийгмийн баталгааг нь хангасан байх. Үүнээсээ илүү чухал ажилдаа цаг алдалгүй ороорой гэж захиж хэлье ээ.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье ээ.

Бид их чухал шийдвэр юм гаргах гэж байна. Учир юу гэхлээр зэрэг Монгол Улс тодорхой улсуудтай нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажиллах хэлэлцээр байгуулж тэрийгээ Улсын Их Хурлаараа соёрхон батлуулдаг, нөгөө талынхаа Улсын Их Хурлаар, парламентаар жишээ нь батлуулдаг ийм жишиг тогтоод даруй бидэнд нэг 10 гаран жил болж байна. Үр дүнгүүд гарч байгаа гэдгийг зориуд хэлмээр байна.

Монгол Улсын иргэд гадаад улсад оршин суудаг, амьдардаг, энэ хугацаандаа ажил хөдөлмөр эрхэлдэг тэр үеийн нийгмийн хамгаалал, тэрнээс гадна тухайн хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үед тэтгэвэр тогтоолгох боломжийг нь олгож байгаагаар энэ өөрөө их чухал юм байгаа юм. Энэ олон улсын хэмжээнд нийгмийн хамгааллын чухал зорилтыг бид хамтдаа хэрэгжүүлж байгаа ийм арга хэрэгсэл.

Өнөөдөр бид БНКАУ, Монгол Улсын хооронд нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажиллах энэ хэлэлцээр байгуулагдсан ч гэсэн энийг соёрхон батлах гэж байна. Үүний цаана даруй одоо яг өнөөдрийн статистикаар бол Казахстан улсад оршин сууж, ажил хөдөлмөр эрхэлж байгаа 8 мянга гаран иргэдийн асуудал байгаа юм. Нөгөөтэйгүүр тэнд нүүж очсон жараад мянган иргэдийн нийгмийн хамгаалалттай холбоотой асуудал бий. Монгол Улсын иргэд ажил хөдөлмөр эрхэлж байгаад эх орондоо буцаж ирсэн үеийн мэдээж хэрэг нөгөө талын бас иргэдийн Монгол Улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа үеийн нийгмийн хамгаалал учраас энэ өөрөө их тийм онцгой ач холбогдолтой шийдэл болж байна. Шийдэл болчихсон. Энийг бид хэрэгжүүлэх энэ алхыг цохиход бэлэн байгаа нь сайшаалтай байна гэж бодож байгаа юм аа.

Цаашдаа ч гэсэн Монгол Улс бусад улсуудтай энэ хэлэлцээрийг үргэлжлүүлнэ. Монгол Улсын иргэд Австрали улсад бий, Австри улсад бий. Олноороо жишээ нь оршин сууж, ажиллаж амьдарч байгаа улсууд бий.

Нөгөөтэйгүүр жишээ нь бид зарим улсуудтай хэлэлцээрийг шинэчлэх шаардлага ч бий. БНСУ-д ажиллаж амьдарч байгаа Монголчуудынхаа нийгмийн хамгааллын өнөөдрийн хэрэгжүүлж байгаа хэлэлцээрийг шинэчлэн байгуулах шаардлага бий. Энэ чиглэлээр өнгөрсөн хугацаанд бол тухайн үеийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам онцгой ач холбогдол өгч хүчин чармайлт гаргасан.)е үеийн сайд нарыг заавал дурдах ёстой. Ариунзаяа сайдын үед энэ хэлэлцээрийг их эрчимжүүлж, Булгантуяа сайдын үед бол энэ хэлэлцээр байгуулагдсан.

Тэгээд өнөөдөр Аубакир сайдын үед энэ хэлэлцээр Улсын Их Хурлаар соёрхон батлагдаж байна. Соёрхон батлагдсан даруйдаа энэ хэлэлцээр хэрэгжээд явна гэж үзэж байна.

Тэгэхээр зэрэг Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг Монголчуудынхаа нийгмийн хамгааллын баталгааг хангахад чиглэсэн өндөр насны тэтгэвэр, бусад жишээ нь нийгмийн хамгааллын асуудлыг шийдэхэд чиглэсэн энэхүү хэлэлцээрийг соёрхон батлах чиглэлээр дэмжиж санал өгөхийг хүсье ээ.

Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ 2 улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. Урьд нь Их Хурлын дэд дарга тантай уулзаад санал хүсэлтээ илэрхийлсэн. Энд ийм асуудал байгаа юм аа. Урьд нь 1990 ондоо хөдөлмөрийн гэрээгээр 20-оос 30 мянган хүн гарсан. Тэд нар буцаад хүрээд ирсэн асуудал байгаа. Зарим нь тийшээ бас иргэн болсон асуудлууд байж байгаа.

Тэгэхээр энэ төрийн үйлчилгээний байгууллагад малчид ч их явсан нөгөө талаараа бусад мэргэжилтнүүд ч явсан. Эд нарын тэр НДШ-ийг ингээд тооцохдоо энд ажлын хэсэг гарсан уу? Ер нь хэчнээн мянган хүн байна? Буцаж ирсэн хэчнээн мянган хүн байна. Тэнд байгаа нь хэчнээн мянга байна. Судалгаа гаргасан уу? Тэтгэврийн юуг тогтоохдоо энийг шалгаж байж тогтоохгүй бол бас янз бүрийн асуудал гардаг. Энэ дээр ажлын хэсэг урьдчилаад гаргаж байгаа юу? 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ зөвхөн Казахстан улс биш Солонгос, Америк, Европын орнууд Монголчууд ихээр ажиллаад амьдраад буцаад ирж байгаа. Буцаж ирсэн улс энэ тэтгэврээ тогтоолгож чадахгүй байгаа асуудлууд байж байгаа. Тэгэхээр энэ 2 талын нийгмийн даатгалын сан хамтарч байгаад ер нь ажлын хэсэг гаргаж байгаад жинхэнэ нарийн шалгуураар яахгүй бол энэ болохгүй байх. Энэ тал дээр тийм ажлын хэсэг байгаа юу? Ер нь хэчнээн мянган хүн байна? Тэтгэврээ тогтоолгохоор.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн индрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг нэрээ хэлээд хариулаарай.

А.Хишигбаяо: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэлтсийн дарга Хишигбаяр гишүүний асуултад хариулъя.

Энэ Казахстан улсын Засгийн газартай хамтран ажиллах хэлэлцээрийн тухайд бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2018 оноос хойш ажилласан байгаа. Энэ дээр ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Энэ ажлын хэсэгт ГХЯ-аас хамтран оролцож бид нар энэ хэлэлцээрийг гарын үсэг зурах хүртэл нь хамтарч 18 удаагийн хэлэлцээр хийсэн байгаа. Энэ хэлэлцээрийнхээ хүрээнд ажиллах хүрээнд бид нар судалгаа хийж ГХЯ-тайгаа хамтарч ажилласан. Энэ судалгаанаас харахад бол 1994-өөс 2018 оны хооронд Монгол Улсаас 61.6 мянган Казак иргэн бол Казахстан улс руу шилжсэн байдаг. Энээс буцаад 1700 иргэн нь буцаж Монгол Улсдаа ирсэн гэдэг.

Өнөөдрийн байдлаар Казахстан улсад 8 мянга гаруй хүн амьдарч байгаа. Тэрний 3100 нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа хөдөлмөрийн насны хүмүүс байна. Албан ёсны хөдөлмөр эрхэлж байгаа гэж үзэж байгаа. Энэ хэлэлцээрийн тухайд 2 зохицуулалтыг тусгаж байгаа. Ямар зохицуулалт тусалж байгаа гэхээр Казахстан улс 1998 оноос хойш бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжсэн байгаа. Тэгэхээр 1998 оноос өмнө Казахстан Улсад Монгол Улсад ажиллаж байсан давхардаагүй хугацаануудаа нэгтгэж байгаад аль байгаа, аль өөрөө оршин сууж байгаа орондоо тэтгэврээ тогтоолгох ийм нөхцөлийг тусгасан байгаа.

Хоёр дахь асуудал нь болохоор 1998 оноос хойш Казахстан улсын бүрэн хуримтлалын тогтолцоонд шимтгэл төлсөн хүн бол Казахстан улсын тэтгэврийн сангаас тэтгэвэр авдаг болно оо гэсэн үг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэн 1998 оноос хойш Казахстан улсад шимтгэл төлсөн байх юм бол Казахстан улсдаа тэтгэврээ тогтоолгоод Монгол Улсдаа шилжүүлэн өөрийнхөө дансанд авах ийм зохицуулалтыг тусгасан байгаа. Тэгэхээр ер нь бол Монгол Улсын тухайд харьцангуй цөөхөн мөн жилээ нэмэгдүүлэх асуудал яригдана. Энэ Казахстан улсын хувьд бол энэ 61 мянган хүн дээр нь өнөөдрийн амьдарч байгаа хүмүүс бүгд тэтгэвэр авах нөхцөл нь бүрдэж байгаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: Аубакир сайдаа та минь ямар их удав даа. Томилогдсон өдөр чинь л хэлж байлаа. Улс төрийн энэ алдаа дутагдлаас болж энэхүү хэлэлцээр соёрхон батлах процесс дээрээ уначихлаа. Маргааш яаралтай шууд оруулаад ир ээ. Хэлэлцэх эсэх дээрээ унасан хууль, тогтоомжийг нэг жилийн хугацаанд оруулж ирдэггүй хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлээд явж байгаа процесс дээрээ эцсийн үе шат дээрээ унасан хуулийг шууд маргааш нь өргөн барих ийм боломжтой байсан. 4 сарын хугацаа боллоо. 4 сарын хугацаанд тэтгэвэртээ гарсан иргэдийн боломжийг бид нар үгүй хийсэн. 2024 оны 6 сард энэ хэлэлцээрийг анх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор дэмжсэн байдаг. 2024 оны 10 сард хэлэлцээрт гарын үсэг зурсан байдаг. 2025 оны 5 сард эргээд дахиад өргөн барьсан. Бид нар нэг удаад нь баталж чадаагүй. Маш олон иргэдийн санхүүгийн боломжийг нь бид нар хаасан. Бид нар энэн дээрээ маш хариуцлагатайгаар үүнийгээ ухамсарлах хэрэгтэй.

1998 оноос хойш Казакстан улсын хуримтлалын тэтгэврийн санд шимтгэл төлсөн тэтгэврээ тогтоолгохдоо Монгол иргэд эс үгүй бол тэндээ хуримтлалын сангаас нь тэтгэвэр тогтоолгох эс үгүй бол Монгол дахь дансандаа тухайн төвлөрүүлсэн шимтгэлээ цаг тухай бүрдээ арвижуулсан, хүү тооцсон нэмэгдүүлсэн тэр мөнгөн дүнг авах боломж нь бүрдэж байна. Гэхдээ процесс болоогүй. Монгол Улсдаа соёрхон баталж байж Казахстан соёрхон баталж байж. Тэгж байж сая 1 ирэх оны хагас жилээс л хүчин төгөлдөр мөрдөгдөх болов уу даа. Маш их цаг хугацааг бид нар алдлаа. Монгол иргэнийхээ төлөө төр улс төржиж ийм том алдаануудыг гаргаж байна шүү гэдгийг дахиж энд хариуцлагатайгаар хэлмээр байна аа.

Улс төржиж болох сэдэв гэж байна. Боломгүй сэдэв гэж байна. Тэтгэврийн хуулиудаа тэтгэврийн нэмэлт хуулийнхаа хувийн нэмэлт тэтгэврийн хууль бэлэн болчихсон. Аль хэзээний бэлэн байгаа. Та минь нэг өргөн бариадхаач. Нийгмийн даатгалын багц хууль гээд л нэлээд удаан яригдлаа. Дахиад суурь тэтгэврийнхээ асуудлыг оруулаад ир, өргөн барьчих тэгэх үү? Дамдинням сайдад хандаж үг хэлмээр байна.

Яг энэ тэтгэврийн хэлэлцээртэй адил түлш тогтвортой нийлүүлэх хос гэрээ соёрхон батлах асуудал байгаа. ОХУ-тай байгуулсан гэрээ. Нэгийг нь соёрхон баталсан. Нэгийг нь соёрхон батлаагүй байгаа. Хамтдаа байж байж хүчин төгөлдөр үйлчилнэ гэдгийг бид бүгд ухамсартайгаар ойлгох ёстой.

Хоёр дахь гэрээгээ оруулж ир ээ. Шатахуун түлшний асуудал ямар хүнд нөхцөл байдалд орсныг бид нар эрх биш ойлгож байгаа байлгүй. Дахиад хэлье улс төржиж болох сэдэв байна, болохгүй сэдэв гэж байна гэж. Эдгээр асуудлуудаа

Засгийн газар яаралтай оруулж ир ээ. Нэг минут, нэг секунд тутам үнэ цэнтэй байна шүү гэдгийг хэлмээр байна аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Юуны өмнө энэ Монгол Улс Бүгд найрамдах Казакстан Улсын Засгийн газар хоорондын энэ байгуулсан тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай энэ хэлэлцээрийг бид нар соёрхон батлах асуудлыг ярьж байна. Элэг нэгт Монгол ард иргэдээ эргэн ирэхэд нь буурийг нь тухтай байлгаж, хуулийг нь соёрхон баталж байгаадаа баяртай байгаагаа хэлье ээ. Гэхдээ бас тодорхойгүй хэдэн асуудлууд байгаа учраас салбарын сайд болон холбогдох ажилтнуудаас асууя гэж бодож байна. Монгол Улсын энэ тэтгэврийн тогтолцоотой хэрхэн ер нь уялдуулах бодлоготой байгаа вэ гэдэг нь нэг тодорхойгүй харагдаад байгаа юм. Ямар бодлого баримтлах гэж байгаа юм. Жишээлбэл энэ хэлэлцээрийг манай улсын нийгмийн даатгалын болон Тэтгэврийн тогтолцоонд яг хэрхэн уялдуулах юм бэ? Системийн нийцлийг нь яаж хангах юм бэ? Өнөөдөр чуулган үзээд сууж байгаа гадаадад байгаа манай Монголчууд энийг хараад би яаж энэ тэтгэврээ энэ шимтгэл хуримтлууллаа уялдуулах юм бэ гэдгийг нь тодорхой болгох хэрэгтэй байгаа учраас энэ асуултыг асууж байгаа юм.

Мөн бусад улс оронд ажиллаж байгаа Монголд ажиллаж байгаа, Монголын маш олон иргэд, ялангуяа Өмнөд Солонгос, Япон, Польш, Герман зэрэг улсууд байгаа. Япон, Чех гээд. Энэ иргэд олноор ажиллаж байгаа бусад оронтой байгуулах ер нь чиглэл төлөвлөгөө байгаа юу гэдгийг бас тодруулъя. Мөн гадаад улсад энэ хуримтлуулсан шимтгэл, энэ тэтгэврийн мөнгийг Монгол Улсад шилжүүлэх эсвэл Монголд хуримтлуулснаа тухайн улсад жишээлбэл ашиглах шаардлагатай байх юм бол техникийн болон хууль зүйн шийдлийг нь хэрхэн боловсруулж гаргаж байгаа вэ гэдгийг асууя.

Сүүлийн асуулт бол энэ хэлэлцээрийг хэрэгжүүлснээр Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа хэрхэн ер нь сайжрах вэ? Үүнийг бусад салбар жишээлбэл ЭМД, хөдөлмөрийн хамгаалал гээд энэ салбаруудад хэрхэн энэ өргөтгөх боломжтой вэ гэдэг энэ асуултуудыг асууя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг индрийн 4 дүгээр микрофон.

Ц.Ганцэцэг: Ажлын хэсгийн гишүүн НДЕГ-ын бодлогын хөрөнгө төлөвлөлтийн газрын дарга Ганцэцэг. Мандухай гишүүний асуултад хариулъя аа. Энэ БНКАУ-тай байгуулж байгаа хэлэлцээр маань өөрөө тэнд ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн хувьд Монголын нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хуулиар ямар харилцааг зохицуулж байна? Тэр хуульд заасан нөхцөл боломжийг хангаж байгаа бол Монголын хууль тогтоомжийн дагуу тэтгэврээ бодуулах ийм боломжтой.

1998 оноос өмнө тэнд НДШ төлсөн Монгол Улсад төлсөн энэ 2 давхцаагүй хугацааг нэгтгээд Казакстан улсын талаас Монголын иргэд тэтгэврээ авах ийм боломжтой.

Дээрээс нь Казахстаны тогтолцооны бас давуу тал энэ хуримтлалын тогтолцоонд шилжчихсэн. Монголын иргэн 1998 оноос хойш энэ хуримтлалын тогтолцоонд мөнгөө төлөөд явж байсан бол энэ хуримтлалын тогтолцооноос

тэтгэврээ авах боломжтой. Монгол Улсад бүрмөсөн шилжиж ирсэн тохиолдолд тэр хуримтлагдсан мөнгийг нь Казахстаны тал нэг удаа тооцож өгөх ийм давуу талууд хэлэлцээрт улс болсон байгаа.

Манай улсын хувьд бол одоо тэтгэврийн хуулиар ямар харилцаа зохицуулж байна. Насны хувьд шимтгэл төлсөн байх хугацааны хувьд энэ нөхцөлийг хангасан тохиолдолд иргэд маань тэтгэврээ тогтоолгоод авах нь бол нээлттэй боломжтой байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд бусад улсад байгаа Монголчуудын хэлэлцээр хийх үү гэж байна. Ер нь түрүүн ажлын хэсгийн гишүүдээс хариулсан. Монгол Улс Казахстанас гадна 6 улстай хэлэлцээртэй.

Хуучин ЗХУ, БНСУ, Бүгд Найрамдах Польш, Турк, Чех улс, Унгар улстай хэлэлцээр байгуулсан байгаа. ОХУ-тай байгуулсан хэлэлцээрийн хувьд бол 2 улсад ажилласан шимтгэл төлсөн хугацааг нэгтгээд тооцоод тухайн улсын хуулиар нь тэтгэврийг нь тогтоогоод явж байгаа. Солонгос улсын хувьд бол арай жоохон ялгаатай. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монголчууд Монголынхоо хуулийн дагуу Монгол Улсдаа тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлөөд явж байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд энэ хугацаа НДШ төлсөн хугацаандаа ороод Солонгост ажилласан Монголчууд маань Монголынхоо хуулийн дагуу тэтгэврээ тогтоолгоод аваад явах ийм боломж нь нээлттэй.

Бусад Унгар, Турк, Польш, Чех гээд энэ улсууд бол энэ нийгмийн хамгааллын хэлэлцээр нь олон улсын сүүлийн үеийн нийгмийн хамгааллын хэлэлцээрийн чиг хандлагын дагуу хийгдсэн. Энэ ямар агуулгатай байна гэхээр үндсэндээ тухайн улсуудад ажиллаж шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцоод тэгээд тэтгэврийн эрхийг нь өөрийн улсынх нь хууль тогтоомжийн дагуу эрхийг нь үүсгээд тэгээд улс улсад ажилласан жилд нь ноогдох тэтгэврийг тухайн улсуудаас өгч байгаа.

Жишээлэх юм юм бол Унгар улсад 20 жил Монголдоо 10 жил ажилласан хүн бол нийтдээ 30 жилээр тэтгэврийг нь бодоод 20 жилд ноогдох тэтгэврийг нь Унгарын талаас, 10 жилд ноогдох тэтгэврийг нь Монголын талаас өгөөд ингээд явж байгаа. Зүгээр Монгол Улсын иргэдийн хувьд бусад хэлэлцээргүй оронд амьдарч ажиллаж байх үедээ тухайн улсууд.

Б.Пүрвэдорж: Нэмж хариулъя.

Ц.Ганцэцэг: Хамгийн сүүлийн асуултад хариулъя. Монгол Улсын энэ хэлэлцээргүй орнуудад ажиллаж байгаа, амьдарч байгаа Монголчууд байгаа.

Тэр улсынхаа хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгал юм уу тэтгэврийн даатгалд хамрагдаад явах нь нээлттэй. Зарим одоо эх сурвалж гэдэг юм уу Монголчуудын хувьд бол Монголынхоо нийгмийн даатгалд сайн дураар даатгуулаад ингээд явж байгаа. Энэ нь нээлттэй. Хэрвээ сайн дурын даатгалын тэр шимтгэл төлсөн хугацаа хүрэлцээтэй бол мөн Монголынхоо хуулиар тэтгэврээ тогтоолгоод явах ийм. эрх зүйн зохицуулалт байгаа.

Б.Пүрвэдорж: Мандухай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Би яг энэ хариулттай холбоотойгоор би түрүүн асуусан. Ер нь энэ бусад ер нь оронтой байгууллага ер нь чиглэл төлөвлөгөө ямар ямар улсууд дээр цаашид ажиллаж байгаа вэ гэдгийг тодруулаад хэлээд өгөөч.

Б.Пүрвэдорж: Индрийн 4 дүгээр микрофон тодруулъя.

Ц.Ганцэцэг: Одоогийн байдлаар бид нар Австри улстай БНАУ-тай хэлэлцээр үндсэндээ хийгдсэн. Монгол Улсын талаас Улсын Их Хуралд өргөн барихаар бэлдэж байгаа.

Дээрээс нь Австралийн Холбооны Улстай хэлэлцээрийн ажил хийгдэж байна. Ирэх 7 хоногоос тэндээс албаны хүмүүс ирж энэ хэлэлцээр дээр ажиллана. Цаашдаа түрүүн манай ТНБД хэлсэн. Швед улс, АНУ гээд энэ бусад орнуудад ажиллаж байгаа Монголчуудын нийгмийн хамгааллын асуудлаар судлаад хэлэлцээрийн асуудлыг үргэлжлүүлнэ гэсэн байдлаар төлөвлөж байна.

Б.Пүрвэдорж: Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн чуулганы үеэр Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах лобби буюу дэмжих бүлэг байгуулагдсан талаар та бүхэнд мэдээлэл хүргэж байсан. Тэгээд миний бие энэхүү дэмжих бүлгийг ахлан ажиллаж байгаа бөгөөд яг өнөөдрийн хэлэлцэж байгаа энэ асуудалтай холбоотой маш их санал хүсэлт ирдгийг энэ дашрамд дурдмаар байна аа. Мөн лобби бүлгийнхээ гишүүд, түүнчлэн хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдээ төлөөлөөд энэхүү хэлэлцээр орж ирж байгаад талархаж байгааг уламжлан дамжуулмаар байна.

Хэдэн зүйлийг тодруулаад асуучихмаар байна. 1982 онд ЗХУ Одоогийн Орос ОХУ-тай, 2006 онд Солонгостой, 2011 онд Унгар улстай, 2018 онд Польш улстай, 2018 онд Турк улстай, 2019 онд Чех улстай энэхүү хэлэлцээрийг байгуулж байжээ. Ингээд өнөөдөр бид Казахстан улстай буюу 7 дахь улстай энэхүү хэлэлцээрийг байгуулах асуудлыг хэлэлцэж байна. Түрүүн гишүүд зөндөө хэллээ. Энэ бол Монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах тухай асуудал учраас та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм аа.

Америكت байгаа Монгол иргэдээс маш их хүсэлт ирдэг ээ. Америкийн Засгийн газартай байгуулах энэ гэрээний асуудал миний ойлгож байгаагаар Монгол Улсын Засгийн газраас нэлээд хэдэн жилийн өмнө хүсэлтээ явуулсан байгаа гэж би ойлгосон. Энэ ажил маань одоо хэр байгаа юм бол оо. Хэр хурдан шийдэгдэж чадах юм оо гэдгийг нэгэнт тодруулмаар байна.

Дараагийн нэг зүйл болохоор юу вэ гэхээр тухайн улс орондоо жишээ нь Америкт ч юм уу авч байсан төлж байсан шимтгэл нь цалин нь өндөр байгаа төлж байсан шимтгэл нь өндөр байгаа тохиолдолд тэрийг яаж тооцдог аргачлал байдаг вэ? Тэр өндөр хэвээрээ тооцогддог уу, эс үгүй бол өөр аргачлалд тооцогддог уу гэдгийг тодруулмаар байна аа.

Төгсгөлд нь хэлэхэд зарим гишүүд сая хэлээд байна. Энэ хэлэлцээрийг соёрхон батлах тухай асуудал түрүүн Их Хурлын дарга хэлсэн. 3-ны 2-оор батлагддаг. 64 гишүүнээр. Өнгөрсөн удаад Их Хурлын чуулганаар ороод ирц хүрэхгүйн улмаас энэ уначихсан ийм асуудал гарсан шүү. Тийм учраас ирцээ сайн

бүрдүүлж энэ удаад хариуцлагатайгаар гишүүд маань санал дэмжээд саналаа өгөөд өгөөрэй гэдгийг онцгойлон хүсмээр байгаа юм аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Индэрийн 4 дүгээр микрофон хариулъя. Нэрээ хэлээд хариулаарай.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Мөнхзул гишүүний асуултад хариулъя аа.

АНУ-д амьдарч байгаа Монголчуудын хувьд бол НДШ төлдөг. АНУ бас тэтгэврийн нэгдсэн системгүй. Үндсэн план (401) к планаас гадна хэд хэдэн өөр планууд байдаг. Манай иргэдийн тавьж байгаа гол хүсэлт маань юу гэхээр АНУ-аас ямар нэгэн байдлаар бүрмөсөн буцах тохиолдолд тухайн улсад төлсөн шимтгэлийг буцааж авъя гэдэг ийм хүсэлтийг тавьдаг. Бид нар АНУ-ын Засгийн газартаа 2016 оноос эхэлж энэ талын хүсэлтийг уламжилж ирсэн. Хамгийн сүүлд албан ёсоор 2018 онд манай хуулийн нөхцөл байдлыг судалж үзээд танай Монгол Улсын иргэдийн шимтгэлийг 2 тал зэрэг төлөхгүй, шимтгэл төлүүлэх энэ хэлбэрээр явуулах боломжтой. Гэхдээ одоо бол бид асуудлыг шууд авч үзэх боловч хууль эрх зүйн хувьд боломж байгаа боловч одоо авч үзэх боломжгүй байна гэдэг хариу өгсөн.

Уг асуудлаар Монгол Улсаас АНУ-д одоо ажиллаж байгаа Элчин сайд нэлээн чармайлт гаргаад өнгөрсөн оноос эхэлж Америкийн хөдөлмөрийн департаментдаа нэлээд ажиллаж байгаа. АНУ-аас тэтгэвэр нэгтгэн бодох ийм хүсэлт бол хэлэлцээрийн хэлбэрийг санал болгосон байна лээ. Бид тэтгэврийг нэгтгэн бодох нь Монгол иргэдэд төдийлөн ашигтай биш учраас төсвийн шимтгэлийг АНУ гарах тохиолдолд олгуулах шимтгэлээс харилцан чөлөөлөх гэсэн хэлэлцээрийн 2 дахь хувилбараар судалж ажиллаж байгаа. Тэгээд энэ асуудлаар өнгөрсөн сард Монгол Улсын ЭСЯ-тай бид нар нэлээд нягт ажиллаж, мэдээлэл солилцож, энэ асуудлыг шуурхайлахаар Гадаад хэргийн яамтай хамтарч ажиллаж байна аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хоёр гишүүний дараа асуулт асууж, үг хэлсний дараагаар санал хураалттай. Гишүүдийг танхимд урьж байна. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Д.Ганбат: Энэ хэлэлцээрийг бол соёрхон батлахыг дэмжиж байна аа. Ер нь Казахстан улс маань өнөөдөр нэг хүнд ноогдох нь 14 мянган доллар байгаа байх. Цаашдаа ч өсөөд Казахстаны эдийн засаг бол өдрөөс өдөрт сайжирч байгаа л даа. Манайх харамсалтай нь өнөөдөр 6 мянга гаран доллар л байна. Уул нь бид нар нэг 30-аад жилийн өмнө адилхан л гараанаас нэг гараанаас эхэлж байсан байхгүй юу. Бид нар арай дээгүүр ч явж байсан. Гэтэл харамсалтай нь энэ нүүрсний хулгайчид энэ бүх юмнуудтайгаа бид нар эвлэрснээс болоод энэ төмөр зам, энэ ажил хэл төрөл хийж байгаа энэ улсууд нь хариуцлагагүйгээс болж манай Монгол Улсын иргэдийн 30 хувь нь ядуу байгаа. Бүүр цаашилбал 50, 60 хувь нь ядуу болчих гээд байгаа юм. Ийм байдалтай байна. Аливаа нэг сайд ажил төрөл хариуцаад ажил хийхдээ ингээд юм үлдээж байх хэрэгтэй. Бакир сайд сайн байна. Ямар ч байсан ажил хэрэг болгоод энэ Монгол Улсынхаа иргэдийг энэ тэтгэврийн сангаас авах боломжийг нь хангаад ингээд энэ хэлэлцээрийг соёрхон батлах энэ түвшинд авчраад өнөөдөр батлуулах гээд сууж байна. Их сайн байна. Үүнээс гадна нөгөө муу хэлээд байдаг Эрдэнэ ч гэсэн хамгийн хүн олон хүн ажилладаг байсан Солонгосыг оруулж ирээд л батлуулж байсан. Бид нар сайн юмыг сайнаар нь хэлчихдэг байх хэрэгтэй.

Нэг юм тодруулъя. Энэ Казахстан улс маань давхар иргэншил зөвшөөрч байгаа юу ямар байгаа вэ? Манай гишүүд юм хум ойлгохдоо зарим нь их тааруу байдаг. Энэ тэтгэвэр чинь шимтгэл шүү дээ. Өөрийнх нь ажиллаж байсан тэр бараг хадгаламж ч гэж хэлж болно ийм л зүйл. Зарим нь бараг халамж төрөөс үзүүлж байгаа юу ч билээ тусламж гэдэг юм уу тиймэрхүү ойлголттой байдаг шүү. Тэгээд тэр ойлголтуудаа засаарай. Ганцхан л тэр даргадаа үнэнч ч юм уу тэр хүндээ зүтгэх ёстой гэсэн ийм ойлголттой хүмүүс их байна. Ер нь энэ Байнгын хороо, чуулган дээр би ер нь байн байн үг хэлж байя гэж бодож байна. Энэ үг хэлж байх асуулт асууж байгаад нөгөө дураараа орж ирж хажуу талаас ярина. Наад зах нь тийм соёлгүй болчихсон байна шүү нөхдүүд. Гэх мэтчилний ийм зүйл байна аа. Тэгээд цааш цаашдаа цөөхөн хэд хоног бараг дөрөвхөн сар болж байгаа Засгийн газар гэхэд хөөрхөн юм амжуулаад байна шүү бас. Сайны нь сайнаар, мууг нь муугаар хэлэх ёстой болж байна. Цаашдаа ч тэгээд сайн ажилла. Тэгээд болохгүй бүтэхгүй байвал бас хэлж яриад арга хэмжээ тооцоход бэлэн байгаа шүү гэдгийг хэлье ээ. Байрлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Туваан: Дэмжиж байна аа. Тэгээд цаг хугацаа жоохон алдчихсан. Бид хэд нөгөө Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдээ ингээд улс төржиж алдаа гаргаад нэг ийм хор хохиролтой зүйл үлдчихээд байгаа юм. Тэр нь энийг хүлээж байгаа олон иргэдийн нийгмийн даатгалын, тэтгэврийн асуудал байгаа. Үүнтэй адилхан сая бид нар энэ бензин дээр ч гэсэн нөгөө газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээрийг нь батлаад тэгээд нөгөө онгоцны түлш гэсэн чинь бүүр Чингис хаан буудлаа алдах гэж байна гээд ярьсаар байгаад ингээд зогсоочихсон. Тэгээд тэрний асуудал чинь сая энэ бензин дээр сүүдэр нь тусаж л байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ асуудлыг энэ хэлэлцээрийг яаралтай батлаад өгсөн нь зөв өө гэж ингэж бодож байгаа юм. Энэ асуудалтай адилхан кэйсүүдийг анх АН-аас сонгогдсон АН-ын яг энэ салбарын сайд хийж байсан Содномзундуй Эрдэнэ анх нэлээн ярьж байсан. Солонгос манай улсын гадаадад ажиллаж байгаа хүмүүсийн ихэнх нь ажилладаг Солонгос улстай энэ хэлэлцээрийг маш амжилттай хийж чадаад энэ хэлэлцээр хэрэгжээд явж байгаа.

Тэгэхээр цаашдаа Монгол хүн ажиллаж байгаа бүх улсуудад энэ хэлэлцээрээ хийчихсэн нь зөв өө гэж ингэж ойлгох хэрэгтэй. Яагаад гэхлээр энэ өөрөө хүмүүсийн ахмад насандаа хүрээд тэтгэвэртэй болох үед нь шаардагдах маш чухал асуудал учраас энийг яаралтай шийдэх ёстой юм байгаа юм. Энэ хэлэлцээр Засгийн газар хоорондын хэлэлцээр учраас бид нар өмнө нь 64 буюу 64-өөс дээш гишүүнээр ингээд хэлэлцэх дэмжих ёстой байж байгаад ингээд уначихсан. Үүнээс хойш тодорхой хугацаа өнгөрсөн байна.

Өнөөдөр бол энийг бид нар батална гэж ингэж ойлгож байгаа. Ер нь бол бид нар 208 гээд албаныхан хэлж байна. Тэгээд зарим гишүүд 230, 240 мянга гээд. Монгол Улсын хамаг л сор болсон залуучууд гадаад улсад хатуухан хэлэхэд боолын хөдөлмөр эрхэлж байгаа. Тэнд хүний эрхийн зөрчил, бусад зөрчил, ажлын байрны дарамт, янз бүрийн дарамт шахалтуудын доор Монгол залуучууд ажиллаж байгаа. Монгол залуучууд тэнд гайхагдахаар хэмжээнд маш их ачаалал авч маш их ажлыг хийж амжуулж ажиллаж чаддаг. Тэгэхээр бид нар бол одоо энэ асуудлуудаа ялангуяа энэ төсөв хэлэлцэгдэж байгаа үед нийгмийн даатгалын асуудал

хэлэлцэгдэж байгаа үед цалин цавууны асуудал хэлэлцэгдэж байгаа үед бид нар олигтойхон байж энэ залуучуудаа Монгол орондоо ажиллаж амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэх талд хэдүүлээ илүү их анхаарч ажиллах шаардлагатай байгаа гэдгийг энэ дашрамд хэлье ээ. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Тэгэхээр 1997 оноос хойш хөдөлмөрийн гэрээгээр нийтдээ 48 мянга орчим Казах иргэд БНКАУ-д очиж ажилласан байдаг. Сүүлд Казак иргэдийг олонх болгох зорилгоор тодорхой хөрөнгө олгох замаар 47 мянга орчим иргэн Казахстан улс руу иргэн болж явсан байдаг. Тэгээд ингээд үзэээр нэг 95 мянга орчим Казак иргэдийн асуудал тэндээс буцаж ирж Монголын харьяат болсон энэ хүн эдгээр хүмүүсийн асуудлыг энэ хэлэлцээрийн хүрээнд шийдэхээр байгаа. Яг Монгол Улсад Казахстан улсаас хөдөлмөр эрхэлж байгаа хүн бол маш цөөхөн.

Тийм учраас энэ хэлэлцээр бол Монгол Улсын хувьд бол маш тийм үр ашигтай ийм хэлэлцээр болж байгаа. Тийм учраас энэ Их Хурлын гишүүдийг энэ дээр бүгдээрээ дэмжиж саналаа өгөхийг хүсэж байна. Манай МАН-ынхан сая бүгдээрээ нөгөө ирийтэл суусан байсан. Яагаад байхгүй байна. Одоо энэ дарга гэхээр л бүгдээрээ орж ирээд суучихдаг. Ойрын үед энэ намынх нь Их Хурал болж байгаа. Ийшээ тийшээ ингээд анхаарах их асуудалтай байгаа байх. Тийм учраас АН-ынханд маш том хариуцлага ирж байгаа. Та бүхэн энэ төсвийн хуулиа батлахгүй бол энэ ирэх жилийн төсөв 15 гэхэд хэлэлцэгдэж батлагдахгүй бол Их Хурал чадамжгүй гээд тарах ийм нөхцөл байдал руу орно. Тийм учраас энэ есхөн хоногийн асуудал байна. АН-ынхан ирцээ сайжруулж, тэр энэ зарим нэгэн ирдэггүй гишүүд энэ Баттулга гишүүн энэ тэрийгээ дуудаж ирцээ сайжруулж Байнгын хороонуудын хуралд оролцуулж энэ төрийн өмнө хүлээх тэр ажлуудаа маш сайн хийх хэрэгтэй байна.

Тийм учраас хариуцлага та бүхэн дээр ирсэн шүү. Энэ төсвөө батлах нь бол Монгол төрийн өмнө хийж байгаа ам том үүрэг шүү гэдгийг хэлье. Тэгээд АН-ынхан ажлаа сайжруулаарай гэж хэлмээр байна.

Санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэе.

Далан гишүүн л байна шүү. Яг далан гишүүн байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Бэлтгэчихсэн.

Санал хураалт.

Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана.

78 гишүүн дэмжлээ.

Цогтбаатар гишүүн, Батбаяр гишүүн, Одбаяр гишүүн, Баясгалан гишүүдийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн тул Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархлаа.

Дэд даргыг сонгосонтой холбоотой Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай Их Хурлын тогтоолын төсөл 4 дүгээр асуудлаар хэлэлцэх байсан. Энэ Их Хурлын дэд дарга томилогдоогүй учраас хойшлогдож байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

15.06 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА